



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/139

Арвайхээр

Салбар комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” 173 дугаар тогтоолын 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Салбар комисс байгуулах тухай” а/113 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0297

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 24-ны өдрийн
1139 дугаар захирамжийн
хавсралт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР КОМИСС**

Комиссын дарга: Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Г.Оюунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөгжлийн
бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Гишүүд: С.Долгорсүрэн (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй
хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, “Тэгш
боломж” эцэг эхийн холбооны тэргүүлэгч)

Г.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх
Боловсрол, шинжлэх ухааны газрын Хөгжлийн
бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Г.Тогтохдулам (Бүсийн оношилгоо, эмчилгээний
төвийн Хүүхдийн тасгийн эрхлэгч, хүүхдийн их эмч)

Г.Цэндмаа (Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн
Мэдрэлийн тасгийн мэдрэлийн их эмч)

Х.Пүрэвсүрэн (Арвайхээр сумын Ерөнхий
боловсролын 2 дугаар сургуулийн тусгай бүлгийн
багш, согог зүйч)